

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос нийлүүлэх гэж буй бараанд үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Шаардлагатай тохиолдолд захиалагч загвар, дээжийг шалгаж, туршиж болох ба шалгалт, туршилт хийсний үр дүнд тухайн загвар, дээжийн үндсэн шинж чанар алдагдсан, зориулалтын дагуу дахин ашиглах боломжгүй болсон тохиолдолд оролцогчид буцааж олгохгүй тухай техникийн тодорхойлолтод заана. Бусад тохиолдолд гэрээ байгуулсны дараа шалгарсан оролцогчийн загвар, дээжээс бусад загвар, дээжийг буцааж олгоно.

Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

1

Техникийн тодорхойлолт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.
Барааны нэр: *Max, махан бүтээгдэхүүн-*

№	Захиалагчийн техникийн тодорхойлолт (Тухайн барааны узүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	Санал болгож буй техникийн тодорхойлолт (захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	Тайлбар (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)

1	<ul style="list-style-type: none"> -Үхрийн мах, -Хонины мах -Ямааны мах 	<p>1.Эрүүл ахуй, ариун цэврийн стандартад нийцсэн, гарал үүслийн гэрчилгээ бүхий 1 дүгээр зэргийн, өнгө, үнэр, биет байдал, гадаргуу, хэлбэр алдагдаагүй мах байна.</p> <p>2.Махыг хэсэглэж ангилсан байдлаар нийлүүлэх тохиолдолд MNS 2456:2009, MNS 2457:2009 стандартуудын шаардлагыг хангасан байна.</p> <p>3.Эрүүл ахуй, аюулгүй байдлын үндсэн шаардлага хангасан, эрүүл мал, амьтнаас бэлтгэсэн байна.</p> <p>4.Мал эмнэлэг, ариун цэвэр, гарал үүслийн гэрчилгээ, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичигтэй байна.</p> <p>5.Загсаасан буюу сэrvээсэн эсвэл хөргөсөн, хөлдөөсөн мах байна.</p> <p>6.Гулууз болон өрөөл мах нь хэвлийн цагаан шугамын дагуу тэгш ярагдсан, улаан хоолой, мөгөөрсөн хоолойг бүрэн салгасан, дотор өөхний үлдэгдэлгүй, нөжирч хурсан цус, сэвс, үс, шороо зэрэг гадны бохирдолгүй, гадаргуу нь урагдаж гэмтээгүй байна.</p> <p>7.Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгсэлээр тээвэрлэнэ.</p>	<p>Эдгээр бараануудын гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийг дагалдуулна.</p>
---	--	---	--

		<p>8. Тээврийн хэрэгсэл нь цэвэр, хуурай, гадны үнэргүй, хортон шавьжаар бохирлогдоогүй, шороо, чийгнээс хамгаалсан бүрхүүлтэй байх ба тогтмол ариутгал, халдвартгүйжүүлэлтийг хийсэн байна.</p> <p>9. Тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцад технологийн горимыг чанд мөрдөнө.</p> <p>10. Бүтээгдэхүүнийг ажлын 30 хоногийн хэрэгцээг хангахуйцаар нэг удаагийн нийлүүлэлтийг хийнэ.</p>	
--	--	--	--